



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 239

Улаанбаатар
хот


Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг векселиэр баталгаажуулах тухай” Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 72 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад дор дурдсан агуулга бүхий 4 дэх заалт нэмсүгэй:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Нийт авсан санхүүжилт	2016 онд векселиэр олгох дүн	Ажлын явц	Гүйцэтгэгч компани
		Эхлэх	Дуусах					
4	Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн авто зам (132.6 км)	2012	2015	66,298.0	66,278.4	45,140.3	100%	“Арж капитал” ХХК

2. Засгийн газрын 2016 оны 72 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, мөн тогтоолын 3 дугаар хавсралтын нэрийн “шүүхийн шийдвэрийн дагуу” гэснийг “шүүхийн шийдвэр гарсантай холбогдуулан” гэж, хавсралтын “НИЙТ” гэсэн хэсгийн “8,917.9” гэснийг “54,058.2” гэж тус тус өөрчилсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

М.ЗОРИГТ